



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/249

Улиастай

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгах, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгах байгууллагыг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хүчингүй болгох байгууллагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тусгай зөвшөөрлийг сунгасан байгууллагын үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс (Л.Лхамсүрэн)-т, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Эрүүл мэндийн газар (Ч.Дэмчигсүрэн)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (А.Шаравжамц), Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Н.Бямбадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ТҮВШИНЖАРГАЛ



Zahiramj 2021

811210731

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 сарын 28
өдрийн захирамжийн нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ БАЙГУУЛЛАГА

д/д	Байгууллагын нэр	Сунгалт хийсэн он сар өдөр	Дуусах он сар өдөр
1	"Одчим наран ХХК"-ийн Одчим наран ортой эмнэлэг	2021 оны 06 дугаар сарын 17	2026 оны 06 дугаар сарын 17
2	"Гэгээлэн эх үр ХХК"-ийн Гэгээлэн хүүхдийн эмнэлэг	2021 оны 05 дугаар сарын 28	2026 оны 05 дугаар сарын 28

АЙМГИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН КОМИСС

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 сарын 15
өдрийн 249 захирамжийн хоёрдугаар хавсралт

8119285296 ☎ 9039287

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛДАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ БАЙГУУЛЛАГА

д/д	Байгууллагын нэр	Олгосон он сар өдөр Хугацаа дуусах он сар өдөр	Хүчингүй болгох он сар өдөр
1	"Эх тунамал сувдмаа ХХК"-ийн эх тунамал эмийн сан	2019.10.03-2022.10.03	2021 оны 06 дугаар сарын 15
2	"Тайкүн Фармиси ХХК"-ийн Арвижих эмийн сан	2017.12.21-2022.12.21	2021 оны 06 дугаар сарын 15
3	"Одчим наран ХХК"-ийн Одчим сувилал	2017.12.21- 2022.12.21	2021 оны 06 дугаар сарын 15

АЙМГИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН КОМИСС